

Асуудал дэвшүүлсэн өгүүлэл

Байлдааны сум барааны захад зарагдаж, ангийн буу “аминд” хүрсээр...

Д.ДАРАМБАЗАР

Аав нь гурвын гурван алаг үрээ буудаж хөнөөсөн хэрэг гарч, нийгмээрээ халаглаж бас жигшиж байсан цаг саяхан. Энэ санаанд багтамгүй хэргийг үйлдэхдээ хөлчүүрхсэн эцэг ZKK600 буу ашигласан байна. Гэтэл хэдхэн хоногийн өмнө бас л эцгийнхээ үгэнд эгдүүцсэн 15 настай жаал аавыгаа буудсан хэрэг Завхан аймагт гарлаа. Үүнтэй ижил хөлчүүрхсэн үедээ, уурандаа эсвэл санамсаргүйгээр хамгийн хайртай бүхнээсээ хагацаж байгаа кейс ил, далдаар мөн ч олон үйлдэгдэж байгаа. Цагдаагийн байгууллага ч анхааруулсаар байгаа. Тэгвэл яагаад аавын анд үүрдэг буу аминд хүрээд байна вэ. Үүний цаад учир нь хэн нэгний хилэн дэвэрч, “муу” бодол толгойд нь орж ирэх үед гар дор нь галт зэвсэг, сумтайгаа бэлэн “хөглөрч” байгаа учраас хэрцгий хүслийг гүйцэлдүүлж байгаа хэрэг. Энэ мэт галт зэвсэгтэй холбоотой бидний мэдэхгүй олон хэрэг сүүлийн жилүүдэд тасралтгүй гарсаар байна. Үүний гол зүйл болох байлдааны зориулалттай анчдад ашиглагддаг сум барааны зах дээр олон наймаачны гарт ил зарагдаж байна. Тэд амьдралаа залгуулахын тулд хууль бусаар ийм наймаа хийдэг гэдгээ ч нуудаггүй бөгөөд хэдэн зуугаар захиалсан хүнтэйгээ хамтрагчид болон машин тэрэг хөлслөн, өөр хүнд ачиж аваачиж өгдөг гэнэ. Хэсэг бүлэг хүмүүс сумаа зарж, түүнээс хэдэн зуугаар нь авсан иргэд ан хийх нэрийдлээр гэртээ хадгалж байхдаа амь нас эрүүл мэндээрээ хохирсоор байгаа нь галт зэвсэгтэй холбогдох хуул хэрэгжихгүй байгаагийн нотолгоо юм. Харин хуулийг хэрэгжүүлэхийн тулд ажилладаг “Нарантуул” захын цагдаа нар энэ тал дээр юу хийж сууна вэ. Хажууд нь “Сум аваарай” гээд хашхираад явж байгаа иргэдийг хараагүй мэт өнгөрүүлж, улам өөгшүүлэх нь өнөөдрийн энэ асуудлын эх үүсвэр болж байна. Цагдаагийн албаныхнаас энэ талаар тайлбар авахад “Манайд хамгийн их хууль бус худалдаалагч иргэд төвлөрдөг газар бол “Нарантуул” олон улсын худалдааны төв. Худалдаалж байгаа сумнууд нь сайн, муу янз бүрийн байдаг. Тухайлбал калибрын “шар сум”-ийг ихэвчлэн БНХАУ-аас оруулж ирдэг. Тэр сумны хонгионд зориулалтын бус дарь хийсэн байдаг. Улмаар тухайн бууны түлхэлтийн хүч том сумны дарийг халааж чадахгүй байгаад хэсэг хугацааны дараа хонгиондоо дарь халснаар шууд тэсэрдэг. Шалгалтаар очиход ангийн зориулалттай сум л байдаг” гэж галт зэвсгийн бүртгэлийн байцаагч Б.Баярсайхан хариулав. Үүнээс үзэхэд хараа хяналт сул болохыг илтгэж байна. Учир нь байлдааны зориулалтаар ашиглагддаг АК47 бууны сум наймаачдын гарт байна. АК47 бууны сум энгийн иргэд зарах боломжгүй, байлдааны зориулалтаар тусгай нөхцөлөөр Монголд оруулж ирдэг гэдэг нь энэ асуудлын гол шалтгаан юм.

**ШИЛЖҮҮЛЭХ ҮҮ, КАРТ УНШУУЛАХ УУ**

Захын хаалгаар орж, гарах хүн бүрийг уран гоё үгээрээ хоргоож буй 40 орчим насны хэдэн бүсгүйг холоос ажвал тэд бүгд сум худалдаалж буй. Тэд сумны үнэ асууж сурагласан хүмүүсийн ам руу орчих шахаж ямар сум вэ гэж чимээгүйхэн асуух нь тэдний хууль бус худалдаа үргэлжилсээр байгааг илтгэнэ. Танд ямар бууны сум байна гэхэд “ калибр, винтов л одоогоор байна, АК47-М-ых алга. Гэхдээ хэд хоногоос бол АК47-М бууных ирнэ гэв. Анчдын голлон хэрэглэдэг зэвсэг бол АК47-М бууны сум аж. Энэ сум нь зөвхөн АК47-М буунд таарахаас гадна анчдын хэлж заншсан “залгамал” гэх буунд таардаг байна. Тийм ч учраас иргэд энэ бууг ихэд сонирхон чоно, гөрөөс, зээр агнахад тохиромжтой хэмээн АК47-М-ын сумыг ихэд сураглан авдаг байна. Гэтэл байлдааны зориулалттай энэ зэвсгийн сум манай улсад сүүлийн жилүүдэд тасарсан гэх сурагтай. Учир нь АК47-М буу нь зөвхөн цэрэг армийн зориулалттай учраас нийлүүлэгч Орос улс энэ төрлийн сумыг энгийн иргэдэд зарахаа болиод удсан ажээ. Харин манай цэрэг армийнхан энэ бууны сумыг тусгай зөвшөөрлөөр оруулж ирэн, туршилтын буудалтад хэрэглэдэг гэж зэвсэгт хүчний 000 дугаар ангийн захирагч Б.Баатарболд мэдээлж байв.

“Винтовын сум ширхэг нь зургаан мянган төгрөг, дотроо 10, 20 гэсэн ширхэгтэй. Хатуу, зөөлөн гэдгээсээ шалтгаалаад үнэ нь өөр, өөр” гэж үнийн саналаа хэлэн зогсох наймаачид худалдан авагчдад тайлбарлана. Хаанаас авсныг асуухад хэн ч хариулахгүй. Оросоор орж ирсэн сумнууд л гэлцэнэ. “Их хэмжээний сумыг энд авч өгөлцөх нь ил юм биш үү” хэмээн хууль хяналтынхнаас эмээсэн дүр үзүүлэв. Гэтэл нэгэн бүсгүй “Сум зарж байгаа бид айхгүй байхад та нар юунаасаа айдаг юм. Хэрэв их хэмжээгээр авах бол хүргэж өгнө. Зах дотор камертай болсон тул ихээр нь зарахгүй. Хэрэв хүсвэл бид Баянзүрх болон 22-ийн товчоогоор гаргаж өгье” гэв. “Цаана чинь цагдаа ирж байна” гэхэд өнөөх бүсгүй “Зүгээрээ энэ чинь хорооны цагдаа л байна. Яав л гэж. Айх хэрэггүй. Бид өнгөрсөн жил тагнуул болон хууль хяналтынхны нүсэр шалгалтаас хашир суусан” гэж айх айдасгүй сум авахаар очсон хүмүүст үнэ ханшаа хэлэн зогсоно. Мөн хөдөө орон нутгийн хувиараа бизнес эрхэлдэг хүмүүс ч биднээс авдаг. Хүссэн хэмжээгээрээ авсан ч болно” гэж өөр нэг наймаачин хүртэл хэлж байв. Мөн тэрбээр өвлийн цагт голдуу үнэг, чоно, зээр гөрөөс зэрэг том ан агнадаг учраас АК47-М-ын сумны үнэ нь өсдөг. Харин хавар дөхөхөөр тарваганы ан эхэлдэг учраас калибрийн сум сайн зарагддаг гэлээ. Захын бас нэгэн хэсгээр 30 минут хэртэй холхин ажиглахад өнөөх бүсгүй 4-5 хүнтэй уулзаж заримд нь сумаа ширхэгээр өгч, гар утасныхаа дугаарыг солилцож байлаа. 20 гаруй насны нэг залууд сумаа хайрцгаар нь зарсан бололтой 170 мянга боллоо. Шилжүүлэх үү, карт уншуулах уу гэх нь үүний баталгаа болж байв.

### **“АК47”-ЫН 750 СУМ ХУРААН АВЧЭЭ**

Цагдаагийн байгууллага нь муу ажиллаад байна уу, хууль бус наймаачид нь сэргэлэнтээд байна уу. Баянзүрх дүүргийн цагдаагийн хэлтэс “энэ оны байдлаар “Нарантуул” олон улсын худалдааны төвөөс карбин маркийн бууны сум 500

ширхэг, калибр 900 ширхэг, АК47 750, бинтов 456 ширхэг сум хураасан” гэх тоо хэлсэн. Дээрх тооноос харахад хамгийн их нь ангийн жижиг бууны буюу калибрын сум байна. Манай улсад зэвсэг эзэмшигч дийлэнх иргэд хөдөө орон нутагт байдаг. Гэтэл хоёрдугаарт АК47 хэмээх байлдаан, том ангийн зориулалттай бууны сум “давхиж” яваа нь нэн анхаарал татмаар. Энэ том бууны сум яах гэж ийм ихээрээ орж ирж байна вэ. Тэрхүү хураасан сумнаас хураагдаагүй нь энэ тооноос их байх нь ойлгомжтой. Учир нь цөөхөн ширхэг сумны зөвшөөрөл авчихаад түүнээсээ хэд дахин ихийг оруулж ирдэг гэдгийг эх сурвалж хэлж байв. Үүний цаана танил тал, хээл хахууль байгаа гэхэд хилсдэхгүй. Харин сүйхээтэй, азтай нэг нь далдуур оруулаад амжчихна. Энэхүү АК47-ын эзэд нь бүгд өөрсдийгөө ангийн хорхойтнууд гэж авгайлах томоохон бизнесмэнүүд, ангийн бизнес эрхлэгчид байдаг гэх.

### **ХӨДӨӨ ОРОН НУТАГТ ИХ ХЭМЖЭЭГЭЭР СУМ ЗАРАГДДАГ**

Мөнгөтэй л бол хэдэн тоогоор нь авах боломжтой зүйлсийн нэгээн сум тодорч байна. Уг нь сумны хязгаарлалт гэж зүйл байх ёстой атал хөдөө орон нутагт хэн дуртай нь зарж мөнгө болгож байна. Завхан аймгийн Улиастай сумын Жинст багийн Хайрхан хүнсний дэлгүүрт энэ оны наймдугаар сард калеврын сум худалдана гэсэн зар байршив. Зарын дагуу очиход дэлгүүрийнх нь лангуу дээр ил зарагдаж, түүнээс үнэ асуусан хүмүүс тасрахгүй байгаа ажиглагдана. Хүмүүс ч 130 мянга юм уу гэж асуун 2-3 хайрцагийг нэг дор худалдаж авч байгаа харагдав. Үүнээс гадна Улаанбаатар хотын харьяат 27 настай Ц Toyota Prius маркийн автомашинд 7.64 мм байлдааны зориулалттай 50 ширхэг сум зарах гэж Орхон аймгийн Баян-Өндөр суманд очсон нь үүний баталгаа. Үүнээс үзэхэд сумны худалдаа хөдөө орон нутгийн дэлгүүрийн лангуу дээр ил байгаа мэт зөвшөөрөлгүй худалдаалагдсаар байгаа юм. Сум худалдаалагчдыг анзаарах хууль хяналт, төр гэгч алга. Уг нь Засгийн газраас гаргасан галт зэвсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2015 онд хэлэлцэж УИХ-аар баталсан. Цэрэг, хүчнийхний ашиглаж байгаагаас бусад галт зэвсгийг ашиглахтай холбоотой харилцааг зохицуулах, улам нэмэгдэх хандлагатай байгаа галт зэвсэг хэрэглэгчдийн тоог хязгаарлах зорилгоор энэхүү хуулийн төслийг санаачилж хууль бус зэвсгийн “сум” худалдаалахыг таслан зогсоох тухай хэмээн баталсан. Хуулин дээрээ зөвшөөрлийн бичиггүй бол сум наймаалцах боломжгүй. Хэрэв зөвшөөрөл авсан тохиолдолд өөрийн ажиллуулж байгаа буудлага үйлдэх байгууламж /тир/-д худалдаа наймаа хийх боломжтой. Мөн галт зэвсэг, сум худалдах төв /цаашид "Төв" гэх/ ажиллуулах эрх улсын хэмжээнд гурваас илүүгүй хуулийн этгээдэд олгогдоно гэж заасан. Гэтэл “хууль бус сумны наймаа” хэмээн нэрлэгдэх нэгэн төрлийн бизнес хаа сайгүй “цэцэглэж” газар авчээ. Мөн зөвшөөрөлгүй худалдаалах бууны сум дахь зориулалтын бус даринь агууламжтай хадгалагдаж байгаа нь бас нэг сэтгэл түгшээмээр явдал. Бас ээж, хүү, аав гээд гэр бүлийн бизнес ч болж байна. Тэд төрөөс ч, хуулиас ч үл эмээнэ. Тэднийг цагдаа ч үл анзаарна. Гэтэл хуулиасаа ухаан алдатлаа айж, гар, хөл, нүүр амаа нүд хальтрам болтол түлж, амиа алдахын дэнсэн дээр

очсон ч чимээгүй гэгч нь амаа таг үддэг заншил бас нэг хэсэгт нь тогтсон аж. Энэ талаар “бусдын нүдэнд үл өртсөн” цөөн хэдэн баримт өгүүлье.

**Баримт нэг.** Бодит жишээ учраас түүний нэрийг нууцлах байдлаар Болд гэж нэрлэв. Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын иргэн Болд энэ оны долоодугаар сард калибр маркийн ангийн зориулалттай бугаар Ерөөлөг хэмээх газар тарвага агнахаар явж байжээ. Тэрбээр ангаа буудахаар эхний удаа гохоо дарахад гал аваагүйгээс болж сум нь гараагүй аж. Хэсэг хормын дараа замгаа түлхчихээд шагайх гэтэл гэнэт сум замган дотроо гох дараагүй байхад дэлбэрэн А.Мурат нүүрний баруун хэсэг, нүдний зовхи орчмоо түлжээ, Тэрбээр Улаанбаатар хотоос зургаан сард хоёр хайрцаг калибрын сум авахуулсан нь энэ аж. Тарвага гэгч хүн болгоны ходоодны хорхой хөдөлгөсөн энэ амьтныг ойрын хэдэн жил агнахыг хориглосон. А.Мурат цагдаагийн байгууллагад хандах гэхээр хуулийн хорио зөрчсөн хэрэг болох учраас цагдаад ч хандаж чадалгүй тэндээ намжаажээ.

**Баримт хоёр.** Ховд аймгийн Дуут сумын иргэн 23 настай Г наймдугаар сарын 10-ны орчим мөн л тарвага агнаж байгаад замган дотроо гал авахуулж баруун гараа даринд түлжээ. Аав Алтай нь сум авсан газартай нь “тооцоо бодох”-оор хуулийн байгууллагад хандах гэсэн боловч зөвшөөрөлгүй ан хийж байсан учраас мөн л араа боджээ.

Манай улсад ихэвчлэн Америк, Герман, ОХУ, БНХАУ-аас ангийн зориулалттай гэх сум нэвтэрдэг. Эдгээрээс хамгийн эрсдэл ихтэй, аюултай нь өмнөд хөрш БНХАУ-аас стандартын шаардлага хангаагүй, зориулалтын бус сум худалдаалж байгаль орчин, хүний амь насанд аюул учруулж байгаа талаар холбогдох байгууллага болон иргэд хэлж байгаа нь хууль бус наймаа хэр их газар авч хэн дуртай нь сум худалдаалах боломжтой болсоны баталгаа болов уу. Мөн Монгол Улсын хэмжээнд 2015 онд 33160, 2018 онд 38355, 2019 онд 39271 галт зэвсэг бүртгэгдсэн нь жилд дунджаар 1700 орчим галт зэвсгийг иргэн, хуулийн этгээд шинээр худалдан авч өмчилж, эзэмшиж байгаа бөгөөд “Цаашид галт зэвсэг эзэмшигчдийн тоо нэмэгдэх хандлагатай байгаа” хэмээн нийслэлийн Цагдаагийн газрын Зэвсгийн хэлтсийн байцаагч, ахлах дэслэгч Л.Эрдэнэбаатар хэлж байв. Тиймээс хууль, хяналтын байгууллагынхан энэ асуудал дээр анхаарал хандуулахгүй бол байлдааны сум барааны зах дээр очиж, ангийн буу аминд хүрсээр байна...